



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМ



УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ  
ДЭМЖИХ ТӨСӨЛ



GREENTRENDS  
ENVIRONMENTAL SERVICES

**Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн  
хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлангийн  
төслийн Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт зориулсан  
урьдчилан мэдээлэл өгөх, хэлэлцүүлгийн материал  
тараасан тухай тайлан**

Гэрээний дугаар: [WB/MOF/MINIS/CS/CQS/1.1.14\(d\)/2015](#)

Захиалагч: Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
Улс: Монгол

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл

2019 оны 09 дугаар сар



## АГУУЛГА

1. АЖЛЫН ЗОРИЛГО .....	3
2. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААР УРЬДЧИЛСАН БАЙДЛААР МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БАГЦ МАТЕРИАЛ ТАРААХ .....	3
3. УУЛЗАЛТУУДААР ЯРИГДСАН ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД .....	5
4. АЖЛЫН ҮР ДҮН .....	5

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Багийн бүрэлдэхүүн .....	3
Хүснэгт 2. Хэлэлцүүлгийн материал тараасан огноо .....	3
Хүснэгт 3. Хөдөө орон нутагт хэлэлцүүлгийн материал тараасан материалын тоо, хэмжээ .....	4
Хүснэгт 4. Зохион байгуулагдах хэлэлцүүлгийн байршил, огноо .....	4

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хэлэлцүүлгийн материал тараах уулзалтуудын зураг .....	5
---	---

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН-Аж ахуй нэгж

ХНҮ-Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

УУДБХОДТ- Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл

ЗДТГ- Засаг даргын тамгын газар

## 1. АЖЛЫН ЗОРИЛГО

- ✓ Дэлхийн Банкны Олон нийтийн хэлэлцүүлэг, Мэдээллийн нээлттэй байдлын журам болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмын дагуу Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний (ХНҮ)-ний тайлангийн төслийн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийн талаар тухайн Таван толгойн уурхайн бүс нутагт хамрагдаж буй холбогдох аймаг, сум, төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн удирдлагууд, иргэд, малчид болон ААН-үүдэд урьдчилсан, нээлттэй мэдээллээр хангах, хэлэлцүүлгийн багц материал тараах ажлыг гүйцэтгэх. Ингэснээр хэлэлцүүлгийн оролцогчдыг хэлэлцүүлгийн материалуудтай урьдчилсан байдлаар танилцах, санал бэлтгэж ирэх боломжоор хангах.
- ✓ Хэлэлцүүлгийн зорилго, ач холбогдлыг тайлбарлах, яагаад холбогдох талууд хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох, яагаад орон нутгийн засаг захиргаа хэлэлцүүлгийн бэлтгэл ажилд хамтран ажиллах нь чухал шаардлагатай вэ гэдгийг таниулах.

## 2. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААР УРЬДЧИЛСАН БАЙДЛААР МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БАГЦ МАТЕРИАЛ ТАРААХ

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн (УУДБХОДТ) Төсөл хэрэгжүүлэх нэгж болон Грийнтрендс ХХК хамтран төслийн талбайд хамрагдах, төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй аймаг, сумын ЗДТГ-тай Грийнтрендс ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал Б. Баяржаргал, ахлах мэргэжилтэн А.Ану-Үжин, газарзүй мэдээллийн системийн мэргэжилтэн Г.Өсөхбаяр, Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн мэргэжилтэн Т.Цэцгээ нарын баг 2019 оны 09-р сарын 09-нөөс 10-ны өдрүүдэд Өмнөговь аймаг, Даланзадгад, Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд, Ханхонгор сум, Ханбогд сумын Хайрхан баг /Цагаан хад/-ийн ЗДТГ-т уулзалтуудыг зохион байгуулсан. Уулзалтуудын үед Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулахтай холбоотой мэдээллийг өгч, хэлэлцүүлгийн багц материалуудыг тараан ажиллав.

### Хүснэгт 1. Багийн бүрэлдэхүүн

Байгууллага	Албан тушаал, Нэр
1-р баг	
Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	Байгаль орчин, усны менежмент хариуцсан мэргэжилтэн Т.Цэцгээ
Грийнтрендс ХХК	Байгаль орчны ахлах мэргэжилтэн А.Ану-Үжин
2-р баг	
Грийнтрендс ХХК	Бизнес хөгжил хариуцсан захирал Б.Баяржаргал
Грийнтрендс ХХК	Байгаль орчны газарзүй мэдээллийн системийн мэргэжилтэн Г. Өсөхбаяр

### Хүснэгт 2. Хэлэлцүүлгийн материал тараасан огноо

Сум	Огноо	Цаг
Өмнөговь аймгийн Ханбогд сум	2019.09.09	9:30
Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг /Цагаан хад/	2019.09.09	12:00

Өмнөговь аймгийн Баян-Овоо	2019.09.09	15:00
Өмнөговь аймгийн Цогтцэций сум	2019.09.10	09:30
Өмнөговь аймгийн Ханхонгор сум	2019.09.10	13:00
Өмнөговь аймгийн Даланзадгад сум	2019.09.10	15:00

#### Уулзалтуудаар:

- Хэлэлцүүлгийн зорилго, ач холбогдол, яагаад холбогдох талууд хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох, хот болон орон нутгийн засаг захиргаа хэлэлцүүлгийн бэлтгэл ажилд хамтран ажиллах нь чухал шаардлагатай вэ гэдгийг тайлбарлав.
- Хэлэлцүүлгийн гол материал болох Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөл, Техникийн хураангуй, Техникийн бус хураангуй, саналын дэвтрийг ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч хариуцуулсан бөгөөд Хэлэлцүүлгийн материал хүлээлцсэн маягт бөглүүлж гарын үсэг зуруулав.
- Мөн эдгээр материалуудыг тамгын газрын нэг цэгийн үйлчилгээ болон Иргэдийн хурлын танхимд хэлэлцүүлэг зохион байгуулах өдрөөс 14 хоног, явуулснаас хойш 14 хоног байршуулан, буцаан авахаар тохиролцов. Ингэснээр иргэдэд цаасан хэлбэрээр хэлэлцүүлгийн материалтай танилцаж, саналын дэвтэр дээр өөрсдийн асуулт, саналыг бичгээр ирүүлэх боломж бүрдэж байгаа юм.
- Мөн бүх багийн Засаг дарга нарт дээр дурдсан хэлэлцүүлгийн материалуудыг иргэдэд тараалгахаар хангалттай тоогоор хүлээлгэн өгч Хэлэлцүүлгийн материал хүлээлцсэн маягтыг иргэдээр бөглүүлж гарын үсэг зуруулах зорилгоор хүлээлгэн өгөв.
- Мөн хэлэлцүүлгийг зохион байгуулах огноо, танхим, хурал даргалагч нарыг тохиролцов,

#### Хүснэгт 3. Хөдөө орон нутагт хэлэлцүүлгийн материал тараасан материалын тоо, хэмжээ

Хамрагдах сум	ХНҮ-ний тайлангийн төсөл	Техникийн хураангуй	Техникийн бус хураангуй	Саналын дэвтэр
Өмнөговь аймгийн Ханбогд сум	2	150	350	2
Өмнөговь аймгийн Баян-Овоо	2	90	210	2
Өмнөговь аймгийн Цогтцэций сум	2	120	280	2
Өмнөговь аймгийн Ханхонгор сум	2	120	280	2
Өмнөговь аймгийн Даланзадгад сум	4	240	560	3
<b>Нийт</b>	<b>12</b>	<b>720</b>	<b>1680</b>	<b>11</b>

#### Хүснэгт 4. Зохион байгуулагдах хэлэлцүүлгийн байршил, огноо

№	Хэлэлцүүлгийн байршил	Хамрагдах аймаг, сумд	Огноо	Хэлэлцүүлгийн танхим
1	Өмнөговь аймгийн Даланзадгад сум	Ханхонгор сум	09-р сарын 25, 09:00 цагт	ЗДТГ-ын Иргэний танхим
2	Өмнөговь аймгийн Цогтцэций сум	Баян-Овоо сум	09-р сарын 25, 15:00 цагт	Сумын соёлын төвд
3	Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг /Цагаан хад/	Ханбогд сум	09-р сарын 26,	Монпорд ХХК-ны хурлын танхим

### 3. УУЛЗАЛТУУДААР ЯРИГДСАН ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД

Уулзалт зохион байгуулах, материал тараах явцад Таван толгойн бүс нутагт үүсэж байгаа сөрөг нөлөөллийн гол шалтгаанууд, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хөрсөн бүрхэвчийн эвдрэлийн талаар анхаарал хандуулж байсан. Мөн Таван толгойн нүүрсний бүлэг уурхайгаас үүсэх тоосжилтод өртөх Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн агаарын чанар, нүүрс тээвэрлэлтийн асуудлууд яригдсан.

*Зураг 1. Хэлэлцүүлгийн материал тараах уулзалтуудын зураг*



Өмнөговь аймгийн Ханбогд сум



Өмнөговь аймгийн Баян-Овоо сум



Өмнөговь аймгийн Цогтцэций сум



Өмнөговь аймгийн Ханхонгор сум

### 4. АЖЛЫН ҮР ДҮН

Өмнөговь аймаг, сум, орон нутгийн зүгээс Тавантолгойн нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төслийг боловсруулах ажилд ач холбогдол өгч хамтран ажиллах, ХНҮ-ний тайлангийн төсөл болон бусад холбогдох материалтай танилцах, өөрсдийн оролцоог ухамсарлан, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож хэлэлцүүлгийн үеэр болон саналын дэвтрийн тусламжтай Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай саналуудыг бэлтгэх, хэлэлцүүлгийг олон талын оролцоог хамруулан амжилттай зохион байгуулахад хамтран ажиллахаа мэдэгдсэн. Материал тараалтын ажил нь аймаг, сум, орон нутгийн оролцогч талуудыг мэдээ материалтай танилцах боломжоор хангаж хэлэлцүүлгийн үр дүнг нэмэгдүүлэх олон талын ач холбогдолтой байсан.

Материал тараах ажлын үеэр нийт нэг аймаг, таван сумын 46 иргэдтэй уулзаж мэдээлэл өгсөн (**Error! Reference source not found.**). Таван толгойн нүүрсний уурхайн бүс нутгийн ХНҮ-ний тайлангийн төсөл 12 ш, төслийн техникийн хураангуй 720 ш, техникийн бус хураангуй 1680 ш, санал авах дэвтэр 11 ш тус тус тараасан байна.